

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР
НАЙМГАН” НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-004411

Регистрийн дугаар: 6268048

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОБНУГазрын ахлах мэргэжилтэн:Ц.Жаргалнэмэх

Төв аймгийн БОАЖГазрын ахлах мэргэжилтэн:С.Эрдэнэцогт

Биелэлтийг тайлагнасан:

“Топ Ган Дриллинг” ХХК-ний ерөнхий захирал:.....П.Ганболд

“Топ Ган Дриллинг” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн:.....Н.Гончигмаа

Агуулга

1. ОРШИЛ	4
2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	10
4.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл ...	10
4.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
4.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
4.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл ...	10
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
10. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	17

Зургийн жагсаалт

<i>Зураг 1 Талбайн байрилын тойм зураг.....</i>	<i>5</i>
---	----------

Хүснэгтийн жагсаалт

<i>Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбицол.....</i>	<i>4</i>
<i>Хүснэгт 2 Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ.....</i>	<i>11</i>
<i>Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....</i>	<i>12</i>
<i>Хүснэгт 4 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....</i>	<i>12</i>
<i>Хүснэгт 5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....</i>	<i>14</i>
<i>Хүснэгт 6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө.....</i>	<i>16</i>
<i>Хүснэгт 7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....</i>	<i>17</i>
<i>Хүснэгт 9 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....</i>	<i>17</i>

Хавсралтын жагсаалт

<i>Хавсралт 1 Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 1.5, 1.7, 1.9, 1.10, 1.11 дэх маягтууд</i>
<i>Хавсралт 2 Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл</i>
<i>Хавсралт 3 Улсын бүртгэлийн гэрчилгээ</i>
<i>Хавсралт 4 БОМТ-ний биеллэтийн дүгнэлтийн хуудас</i>
<i>Хавсралт 5 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний дэсгэр зураг</i>

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-004411 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. ОРШИЛ

Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-004411 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай дахь дахь “Ар Наймган”-ны алтны шороон ордын 2025 оны ашиглалтын үйл ажиллагааны байгаль орчныг хамгаалах, менежментийн төлөвлөгөөг ордын талбайд 2018 онд гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, 2022 онд батлуулсан Техник эдийн засгийн үндэслэл зэрэг материалыг үндэслэн боловсруулав.

“Ар Наймган”-ын алтны шороон ордын нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл, эрсдэлийг тооцон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тогтоогдсон ажлуудыг цаг тухай бүрд зардлыг төсөвлөн зайлшгүй авах дараах арга хэмжээнүүдийг дагаж ажиллана.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхдээ биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнд тавих үндсэн шаардлага, байгалийн үндсэн бүсээс хамаарах агротехникийн шаардлага, ургамлын нөхөн сэргээлтийн үе шатууд, тарих ургамлуудыг сонгох болон нөхөн сэргэсэн газрыг хүн, мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах, нөхөн сэргээж буй газрын хөрс, ургамлын хяналт шинжилгээнд тавих шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

“Топ Ган Дрилинг” ХХК нь 2025 оны 2 дугаар сараас эхлэн бэлтгэл ажлуудыг хангаж ажиллахаар төлөвлөөд байна.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Ар Наймган нэртэй MV-004411 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 45 км, ”Шижир алт” суурингаас 1.5 км зайд орших ба талбайн булангийн цэгүүдийн газар зүйн солбилцолыг хүснэгтээр үзүүлэв. Бүс нутгийн хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт, Заамарын нуруу, Туул голын ай сав газарт, дэд бүтцийн тааламжтай нөхцөлд байрладагаараа онцлогтой.

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол

Д/д	Уртраг	Өргөрөг
1	104° 25' 33.63"	48° 18' 16.66"
2	104° 25' 28.1"	48° 18' 16.64"
3	104° 25' 0.93"	48° 18' 16.6"
4	104° 25' 0.93"	48° 17' 53.91"
5	104° 25' 24.94"	48° 17' 53.91"
6	104° 25' 24.94"	48° 17' 31.81"
7	104° 26' 56.74"	48° 17' 31.81"
8	104° 26' 56.78"	48° 18' 8.4"
9	104° 26' 54.94"	48° 18' 8.4"
10	104° 26' 55.04"	48° 18' 0.29"

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-004411 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН АЛТНЫ ШОРООН ОРД ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

11	104° 26' 44.75"	48° 18' 0.24"
12	104° 26' 44.78"	48° 17' 57.98"
13	104° 26' 35.74"	48° 17' 57.93"
14	104° 26' 35.69"	48° 18' 3.44"
15	104° 26' 26.86"	48° 18' 3.39"
16	104° 26' 26.84"	48° 18' 4.88"
17	104° 26' 12.67"	48° 18' 4.81"
18	104° 26' 12.63"	48° 18' 8.7"
19	104° 25' 33.71"	48° 18' 8.5"




Зураг 1 Талбайн байршлын тойм зураг

2025 онд явагдах уулын ажил, ажиллах горим

- ✓ **Ажиллах горим.** Уурхайн ажиллах горимыг 2025 оны уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, ордын ашиглалтын нөхцөл зэргээс хамааруулан дулааны улирлын 9 сар буюу 270 хоногийн хугацаанд, өдөрт 8-10 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллуулахаар төлөвлөөд байна. Уурхай нь 2-р сараас эхлэн уурхайн бэлтгэл ажлууд болон үржил шимт хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж, 3 сарын 01-ээс 11-р сарын 01 хүртэл ажиллахаар төлөвлөв. Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Харин улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амрахаар төлөвлөсөн.

- ✓ **2025 онд явагдах уулын ажил.** 2025 онд доод давхаргын 10-С, 12-С, 13-С, 14-В, 15-С, 22-С, 23-В, 24-С, 47-В, 48-В, 49-С, 50-С, 51-В, 52-С, 54-В, 55-В, 56-В, 57-В, 58-С, дээд давхаргын D1-С, D4-С, D7-С, D8-С гэсэн блокуудыг бүрэн олборлож нийт 7261.5 мян.м3 хөрс хуулж, 119.95 мян.м3 элс олборлон баяжуулахаар төлөвлөж байна.
- ✓ **Үржил шимт хөрс хуулалт.** Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолно. Энэ нь дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм.



- ✓ **Хөрс хуулалтын ажил.** Талбайн үржил шимт хөрсийг хуулсаны дараа хөрсний чулуулгийг экскаватор-автосамосвалын хослолоор хуулан 2023 онд үүсгэсэн уурхайн хоосон орон зайд дотоод овоолгоор уулын ажлыг үргэлжлүүлэхээр төлөвлөв. Хөрс хуулалтын ажлын догол мөргөцгийн өндөр нь ажиллах тоног төхөөрөмжийн үзүүлэлтээс шалтгаалан 7 м байна.
- ✓ **Элс олборлолтын ажил.** Олборлолтын ажлыг экскаватор-автосамосвалын хослолоор ухаж ачин тээвэрлэж, ордоос хойд зүгт дунджаар 1 км зайд байрлах угаан баяжуулах хэсгийн дэргэд байрлах элсний түр овоолго руу зөөж угаан баяжуулахаар төлөвлөв. Мөн угаасан хоосон чулуулгийг эргүүлэн тээвэрлэж уурхайд нөхөн дүүргэлт хийхээр төлөвлөж байна. 2025 онд нийт 7261.5 мян.м3 хөрс хуулж, 119.95 мян.м3 элс олборлон баяжуулахаар байна. Энэ үед уурхай дунджаар 55 м гүн, 320.0 м урт, 200.0 м өргөн байх бөгөөд **6.27 га** олборлолтонд өртөхөөр байна.

Ил уурхайд ажиллах үндсэн техник, тоног төхөөрөмж, бүтээлийн тооцоо. Уурхайн уулын үйлдвэрлэлийн ажилд шаардлагатай үндсэн болон туслах техник, тоног

төхөөрөмжүүдийг “ТОП ГАН ДРИЛЛИНГ ” ХХК-н өөрийн эзэмшлийн техник тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөв. Үүнд:

- 7.0 м3 –ийн багтаамж бүхий утгууртай Komatsu PC1250 маркийн экскаватор
- 6.8 м3 –ийн багтаамж бүхий утгууртай Doosan DX1000 маркийн экскаватор
- 5.4 м3 –ийн багтаамж бүхий утгууртай Doosan DX800 маркийн экскаватор
- 50 тн даацтай БНХАУ-ыг SINOTRUCK фирмийн HOWO-371, HOWO-440 маркийн автосамосвалууд
- 5.4 м3 –ийн хусууртай АНУ -ын CAT фирмийн D7R, D8R маркийн бульдозер
- 3 м3 –ийн багтаамж бүхий утгууртай БНСУ-ын Doosan фирмийн SD300, БНХАУ-ын LW500KN маркийн утгуурт ачигч
- 60м3/цаг –ийн бүтээлтэй ОХУ-ын СБ-60 маркийн угаах төхөөрөмж

Засвар, техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй. Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд шаардлагатай зарим нэг техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээнавах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэдэг. Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлдэг. Засварын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

Шатах тослох материалын агуулах. ШТМ хадгалахад зориулж 25 тн-ын ган сав 1 ш, тос тосолгооны материалуудыг зориулалтын савтай нь хадгалан хэрэглэнэ. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан, зориулалтын тоноглолоор хангасан байна.

Сэлбэг материалын агуулах. Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материал хадгалахад сэлбэг материалын агуулах нь уурхайн хотхонд буюу засвар механикийн хэсгийн хажууд байна.

Машины зогсоол. Уурхайн элс, хөрсний тээвэрт 50 тн даацтай 18 ширхэг автосамосвал ажиллана. Харин уурхайн ажилчдын машин 1 ширхэг, ачааны машин 1 ширхэг, үйлчилгээний машин 1 ширхэг, уурхайн тоосжилт дарах усалгааны машин 1 ширхэг, түлшний машин 1 ширхэг нийт 23 машин байна. Машиныудыг засварын газрын дэргэдэх машины ил зогсоолд байрлуулна

3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Ар Наймган” нэртэй MV-004411 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун хойш 45 км, ”Шижир алт” суурингаас 1.5 км зайд орших ба талбайн булангийн цэгүүдийн газар зүйн солбилцолыг хүснэгтээр үзүүлэв. Бүс нутгийн хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт, Заамарын нуруу, Туул голын ай сав газарт, дэд бүтцийн тааламжтай нөхцөлд байрладагаараа онцлогтой.

Уул зүй: Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэр нь Хангай Хэнтийн уулархаг их мужид хамрагдана. Хангай-Хэнтийн их мужийн уулс голдуу налуу хажуутай тул хөрсөн бүрхэвч бүрэлдэн тогтоход тааламжтай нөхцөлийг бий болгодог.

Ус зүй: Ар наймганы алтны шороон ордын талбай нь гидрогеологийн ангиллаар Хангай, Хэнтийн гидрогеологийн массивт хамаарна. Газрын доорх ус нь уулс хоорондын хөндийнүүдийг дүүргэсэн тунамал хурдас болон дунд ба эрт төрмөлийн гүний ба тунамал-метаморф чулуулгийн ан цавтай холбоотой. Газрын доорх усны түвшин газрын гадаргаас 42-44 м гүнд оршино. Ар наймганы хэмжээнд усны байгалийн нөөц 1448-1933 шоо метр хоног байна. Дөрөвдөгчийн аллювийн хурдсан дах гүний ус нь цэнгэг бөгөөд эрдэсжилт нь 0.4 г/л-с илүүгүй, устөрөгчийн ионы концентраци буюу рН 7.5-8.5, ерөнхий хатуулаг 4.3 мг.экв. Газрын доорх ус нь найрлагаараа ундны усны шаардлагыг бүрэн хангана. Туул голын газрын доорх ус нүүрсхүчлийн хий болон хүчил, сульфат, магнийн зэрэг идэмхий агуулагчгүй учир гидрогеологийн нөхцөлийн хувьд энгийн нөхцөлтөйд тооцогдоно /Хишигтогтох, 2013/.

Уур амьсгал: Уур амьсгалыг бүрдүүлэгч олон хүчин зүйлсийн дотроос нарны цацраг, агаарын орчил урсгал, байгалийн газарзүйн нөхцөл чухал юм. Эдгээрийн харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тухайн газар орны уур амьсгалын нөхцөл бүрэлдэн тогтоно. Төв аймаг уур амьсгалын хувьд сэрүүвтэр, хуурай дулаавтар, мужид багтана.

Заамар сумын уур амьсгал, цаг уурын үзүүлэлтүүд

Төсөл хэрэгжих орчны цаг уур, уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Төв аймгийн Заамар сумын цаг уурын “ЗААМАР” харуулын сүүлийн 10 жилийн мэдээний үндсэн дээр тодорхойлсон болно.

Агаарын температур: Агаар мандлын дулааны горим бол агаар мандал дахь температурын хуваарилалт, хувьсал өөрчлөлтийн явцаар тодорхойлогдох бөгөөд энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын үндсэн элемент болж агаар, хүрээлэн буй орчны

хоорондох дулааны солилцоогоор илэрдэг зүй тогтолтой. 2009-2019 оны агаарын жилийн дундаж температур $-0.7-2.3^0$ байна.

Хур тунадас: Хур тунадас бол тус орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөлийг илэрхийлэгч чухал хүчин зүйлийн нэг юм. Тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалдаг. Хур тунадасны жилийн дундаж хэмжээ нутгийн хойд болон төв, өмнөд хэсгээр 50-58.0 мм, зүүн хэсгээр 60-55.0 мм байна. Хүйтний улирлын хур тунадасны дундаж хэмжээ 70-80 мм дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 80-100 мм нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Заамар сумын хувьд хур тунадасны 2017 оны жилийн хүйтний улирлын хур тунадасны сарын дундаж хэмжээ 11.8-59.4 мм буюу хур тунадас багатай, дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 11.8-60.0мм /6-8 сарын хооронд/ байна. Нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Үүнээс харахад хур тунадас олон жилийн дундаж орчим байна.

Хөрс, ургамал: Төсөл хэрэгжих бүс нутаг нь хөрс газар зүйн ангиллын хувьд Хангайн хөрсний их муж түүн дотор Хангайн мужид тус тус хамаарна. Хангайн их мужид хамгийн түгээмэл тархсан хөрс бол хээрийн хүрэн хөрс бөгөөд орон нутгийн хөрс үүсэх өөр өөр нөхцөлөөс шалтгаалж хүрэн хөрсний хэд хэдэн дэд хэв шинж хар хүрэн, хүрэн, цайвар хүрэн, уулын хүрэн, нугын хүрэн, ойн хүрэн хөрс тус тус тархсан байна /Доржготов, 2003/

Хүн ам, эдийн засаг: Төв аймгийн Заамар сум нь хүн амын суурьшил ихтэй бүс нутагбөгөөд сумын хэмжээнд 3000 орчим хүн амтай. Халх ястан голлон амьдардаг. Голчлон газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг. Заамар уул уурхайн бүс нь зам харилцаа сайтай өвөл, зуны аль улиралд саадгүй аж үйлдвэр, ХАА-н үйлдвэрлэлийн баазуудад ойр байрлана. Тухайлбал Хөтөлийн цементийн үйлдвэрээс 180 км, Дархан хотоос 200 км-т, Улаанбаатар хотоос 240 км-т оршдог. Тус суманд нэг 12 жилийн сургууль, нэг 10 жилийн сургууль, 2 цэцэрлэг, нэг МСҮТ, бүс дундын цагдаагийн газар, 2 хүн эмнэлэг, 150 сурагчийн багтаамжтай дотуур байр, 10 халуун ус, сауны газар, спорт болон урлаг заал тус тус 3, дэлгүүр 40, супермаркет 4, талх нарийн боовны цех болон оёдлын цех тус тус 2, 2 цахилгаан уурын зуух, банкны салбар, шуудан холбоо, Мобикомын станц, “Петровис”, “МТ” компаниудын ШТС-ууд үйл ажиллагаа явуулж байна.

4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

4.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2025 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсч агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

4.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

4.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2025 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

4.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Топ Ган Дриллинг” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй. Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Хүснэгт 2 Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар	1	Тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Нийт тээврийн хэрэгсэл	Мот/цаг, засвар үйлчилгээ	ҮА зардалд	Төслийн хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 - MNS 3384:82
	2	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн зам болон биологийн нөхөн сэргээлтийн талбайг тогтмол услах	-	Нэгж усалгаа	550 000		
	3	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ.	-	-	200 000		
Нийт		750 000					
Гадаргын ба газрын доорх усны нөөц	4	Сав газартай ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөр төлөх	ҮА зардалд			Төслийн хугацаанд	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
	5	Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх	500 000				
	6	Хаягдал ус зайлуулах гэрээ болон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах	ҮА зардалд				
	7	Уст цэгт тоолуур байрлуулан, баталгаажуулах	500 000				
Нийт		1 000 000					
Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	8	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	ҮА зардалд			Төслийн хугацаанд	MNS 5916:2008
	9	Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах	Шимт хөрсний овоолго	Хөтөлсөн бүртгэл	200 000	2025 онд	MNS 5917:2008
	10	Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах Тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг саармагжуулах	Засварын талбай	Хамгаалсан талбай	500 000	Төслийн хугацаанд	MNS 5918:2008
Нийт		800 000					
Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	11	Олон салаа зам гаргахгүй байх, замын тэмдэг тэмдэглэгээ сайжруулах	Уурхайн зам	-	ҮА зардалд	Төслийн хугацаанд	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
	12	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлэх		-			
	13	Орд орчмын амьтны зүйлийн бүрдэл, тархацын судалгаа хийх		-	400 000		
Нийт			500 000				
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 3 050 000							

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 онд **6.27 га** талбайд уулын ажил явуулна. Өмнөх онд үүсгэсэн уурхайг үргэлжлүүлэн олборлолт явуулах тул шууд дотоод овоолгоор уулын ажлыг явуулна. Дотоод овоолгоор **2.5 га** талбайд техникийн нөхөн сэргээлт, **2.0 га** талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийнэ.

✓ Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

✓ Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налуугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

✓ Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай.

Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Техникийн нөхөн сэргээлт	га	2.5	-	4 500 000	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага “MNS 5918:2008”
2.	Биологийн нөхөн сэргээлт	га	2.0	-	10 000 000	
3.	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	ш	33 500	1 000	3 350 000	
4.	Нийт				17 850 000	

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Топ Ган Дриллинг” ХХК нь 2025 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас тогтоож өгсөн 2.0 га газарт өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлтийн ажил хийнэ.

Хүснэгт 4 Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах төлөвлөгөө	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
1	Сумын нутаг нөлөөлөлд өртөж эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ	Нөхөн сэргээлт	га	2.0	-	7 500 000
	Нийт					7 500 000

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Топ Ган Дриллинг” ХХК-ний “Ар наймган”-ын алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. 200,000 төгрөгийг болзошгүй зүйлд хэрэглэхээр төлөвлөв.

10. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, т өг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
1	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	ҮА зардалд	Төслийн хугацаанд
2	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед гадаах ажлыг түр зогсоох		
3	Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах		
4	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах		
5	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн үйлчилгээг нэвтрүүлэх	1 500 000	
Нийт		1 500 000	

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна. Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Энгийн	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын цэг засвар хийх	ҮА зардал	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21-р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл
		Хог хаягдлын төлбөрөө төлнө.			
		Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал	500 000		
		Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	1 500 000		
		Хог хаягдал, ялган ангилалт, түүний үр ашгийн талаар сургалт, мэдлэг олгох			
		Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялган тушаах, дахин ашиглах			
		Ахуйн бохир шингэн хаягдлыг битүүмжлэл сайтай ёмкост хуримтлуулан бохир соруулах машинаар холбогдох газарт нийлүүлэх			
2.	Үйлдвэрийн	Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан	ҮА зардал		
		Хаягдал техникийн тос, маслыг тусгай саванд хуримтлуулах			
		Эмнэлгийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах			
		Үлдэгдэл хог хаягдлыг эцэслэн зайлуулахдаа сумын ТҮК-тай гэрээ байгуулан зайлуулах			
	Нийт зардал 2 000 000				

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах төлөвлөгөө авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- ✓ Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө боловсруулах
- ✓ Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2025 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаар төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

Хүснэгт 7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Агаар	Засварын талбай ажилчдын хотхон, уурхайн карьер, уурхайн зам	5, 8-р сард	4 цэгт 2 удаа	50 000	600 000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO - ын агууламж, Агаар орчны бохирдол дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	Агаарын тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2.	Хөрс	Ахуйн бохир усны хаягдал орчимд, шимт хөрсний овоолго, биологийн нөхөн сэргээлтийн талбай, засварын газар	5, 8-р сард	4 цэгт 2 удаа	Хөрсний хяналт шинжилгээний 3 цэгт жилд 1 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг	1 070 000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	- MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох - MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам
3.	Ус	Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур, ахуйн хаягдал ус	5, 8-р сард	4 цэгт 2 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 50000 төг, Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 141700 төг *УСҮГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ	800 000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ, Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар)	Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995,
	Нийт					2 470 000		

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв төг	Хэрэгжүүлэх хуваарь 2025 он	Хариуцсан албан тушаалтан
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	1 500 000	Төслийн хугацаанд	Уурхайн дарга
2.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх		11-р сар	“Топ Ган Дрилинг” ХХК-ийн удирдлагууд
3	Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.		10-р сараас 12-р сарын 1 нд багтаан	Уурхайн дарга

Хүснэгт 9 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	750.0
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	1 000.0
3	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	500.0
4	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	800.0
5	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	2 000.0
6	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	17 850.0
7	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн зардал	7 500.0
8	Түүх соёлын өв хамгаалал	200.0
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	2 470.0
10	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	1 500.0
11	БОМТ тайлагнах удирдлага, зохион байгуулалт	1 500.0
	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	36 070.0

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардалыг анх 11,830,000 төгрөг байхаар боловсруулж Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөрт 2024 оны 12-р сарын 30-ны өдөр 5,915,000 төгрөг төлсөн ба 2025 оны 04-р сарын 02-ны өдөр 5,920,000 төгрөг, 2025 оны 04-р сарын 17-ны өдөр 6,200,000 төгрөг тус тус төлж нийт Байгаль орчны барьцаа төлбөрт 18,035,000 төгрөг төлж Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардалыг 36,070,000 төгрөг болгож нэмэгдүүлэв.